



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 843

Улаанбаатар хот

### Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг, Төрийн өмчийн хорооны 2001 оны 615 дугаар тогтоолыг тус тус үндэслэн “Мэдээлэл технологийн үндэсний парк” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2021, 2022 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 494,999,527.27(дөрвөн зуун ерэн дөрвөн сая есөн зуун ерэн есөн мянга таван зуун хорин долоон төгрөг хорин долоон мөнгө) төгрөгийн зөрчил дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1.Мэдээлэл технологийн үндэсний парк” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2021, 2022 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.“Мэдээлэл технологийн үндэсний парк” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал (Ж.Золзаяа)-д Үйлдвэрийн газрын дүрэм, Онцгой нөхцөлт бүхий хөдөлмөрийн гэрээнд заасан чиг үүргийг ханган ажиллаж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

2.1.Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх;

2.2.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 60 дугаар тогтоолоор баталсан дүрмийн 4.6-т Үйлдвэрийн газар нь тодорхой мэргэжил, тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг явуулахад холбогдох эрх бүхий байгууллагаас зохих зөвшөөрөл авч, улсын бүртгэлд бүртгүүлснээр тухайн үйл ажиллагааг эрхэлнэ гэж заасны дагуу Технологи, иновацийн дэлгүүрийн зөвшөөрлийг улсын бүртгэлд бүртгүүлэх;

2.3.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээслүүлснээс олсон орлогоос Улсын төсөвт төвлөрүүлэх хувь хэмжээ тогтоох тухай” 49 дүгээр тогтоолын дагуу 2021 онд төрийн өөрийн өмч хөрөнгийг түрээслүүлснээс олсон 9,164,797.3 (есөн сая нэг зуун жаран дөрвөн мянга долоон зуун ерэн долоон төгрөг гучин мөнгө) төгрөгийн 10 хувь буюу 916,479.73 (есөн зуун арван зургаан мянга дөрвөн зуун далан есөн төгрөг далан гурван мөнгө) төгрөгийг Улсын төсвийн дансанд төвлөрүүлэх;

2.4.Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор баталсан Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журмын 19 дүгээр хэсэг, “Мэдээлэл технологийн үндэсний парк” төрийн өмчит үйлдвэрийн газрын захиралтай

123007285  
37-r\_huraldaan.docx

байгуулсан контрактын 3.2.3, 3.2.18 дахь заалтыг мөрдөж ажиллаагүй Хамтран ажиллах гэрээний орлогоос олсон 386,000,000.00 (гурван зуун наян зургаан сая) төгрөгийн 10 хувь буюу 38,600,000.00 (гучин найман сая зургаан зуун мянга) төгрөгийг Улсын төсвийн дансанд төвлөрүүлэх;

2.5.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ыг мөрдөж ажиллах;

2.6.Үйлдвэрийн газрын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг ханган ажиллах, зардлыг хэтрүүлэхгүй байх;

2.7.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох дүрэм журмыг чанд мөрдөж, худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмыг мөрдөж ажиллах;

2.8.“Нью Тур сафарис” ХХК-тай байгуулсан түрээсийн гэрээг дүгнэж, төрийн өмчийн эд хөрөнгийн маргааныг хууль хяналтын эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

2.9.Тус үйлдвэрийн газрын эзэмшлийн газар дээр зөвшөөрөлгүй байрлуулан үйл ажиллагааг явуулж байгаа объектыг зохих хууль тогтоомжийн дагуу шилжүүлэн нүүлгэж газрыг чөлөөлүүлэх;

2.10.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан “Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдлөг болгон ажиллах;

2.11.Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 5.1.2 дахь заалтыг мөрдөж ажиллах;

3.Төрийн өмчийн хорооны хуралдааны 2013 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн “Мэдээллийн технологийн үндэсний паркийн түрээсийн үйл ажиллагааны тухай” тэмдэглэл, Төрийн өмчийн хорооны 2014 оны 363 дугаар тогтоолын гурав дугаар заалтын “в”-дэх хэсгийг хүчингүй болгох асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Д.Дэлгэрмаа)-т даалгасугай.

4.Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

5.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА




Б.ЦЭНГЭЛ

Ц.ТҮВШИНЗАЯА

37-r\_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 843 дугаар тогтоолын хавсралт



“Мэдээлэл технологийн үндэсний парк” төрийн өмчит үйлдвэрийн газарт хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил дутагдлын утга	Мөнгөн дүн (сая.төг)	Авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Үйлдвэрийн газар нь Ай Си Ти Групп ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, гэрээний дагуу барилгын хийц, оффисын засвар үйлчилгээнд хөрөнгө оруулалт хийсэн.	97.93	Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоол, Онцгой нөхцөлт бүхий хөдөлмөрийн гэрээг мөрдөж ажиллах.
2	Төрийн өмчийн эд хөрөнгийг бусдад түрээслүүлэн, олсон орлогоос Улсын төсөвт төвлөрүүлээгүй.	0.92	Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49, 50, 51 дүгээр тогтоолыг мөрдөж ажиллах.
3	Хамтран ажиллах гэрээний дагуу төрийн өмчийн байр талбайг ашиглуулснаас олсон орлого	386.00	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Засгийн газрын 134 дүгээр тогтоол, Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг мөрдөж ажиллах.
4	Зөвшөөрөлгүй үндсэн хөрөнгө бүртгэсэн	4.04	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”
5	Төлөвлөгөөнд тусаагүй шууд худалдан авалт	6.10	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 102 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”
6	Төрийн өмчийн газар дээр зөвшөөрөлгүй байрлуулсан ТҮЦ, хуушуурын газар	-	Газрын тухай хууль, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”
<b>ЗӨРЧЛИЙН НИЙТ ДҮН</b>			<b>494,999,527.27(дөрвөн зуун ерөн дөрвөн сая есөн зуун ерэн есөн мянга таван зуун хорин долоон төгрөг хорин долоон мөнгө)</b>